



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠤ ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/95

Алтай хөг

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, 46.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 04 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2023 оны эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх ГАОНОГ/202212099 дугаартай тендерт оролцож шалгарсан, хавсралтад заагдсан компаниудтай гэрээ байгуулах эрхийг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн нийлүүлэхээр санал болгосон ажлын даалгаврыг үндэслэн холбогдох хууль журмын дагуу эрх, үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2023 оны 02
дугаар сарын 13-ны өдрийн 1195 дугаар
захирамжийн хавсралт

ДДСА0042

ГЭРЭЭ БАЙГУУЛАХ КОМПАНИЙН
НЭРСИЙН ЖАГСААЛТ

Д/д	Компанийн нэр	Сонгосон балцын дугаар
1.	"Монос трейд" ХХК	3, 5, 9, 12, 13, 17
2.	"Монфа трейд" ХХК	6,7, 10, 15
3.	"Энто" ХХК	8, 24
4.	"Айвейко хелт кейр" ХХК	14
5.	"Энхийн шүүдэр" ХХК	19
6.	"Гүн тэнгэрийн нар" ХХК	20
7.	"Мөнхийн тун" ХХК	21, 22
8.	"Монгол фарм" ХХК	25
9.	"Сүвэн уул" ХХК	26
10.	"Эм эс ай си си" ХХК	27
11.	"Еврофарм" ХХК	28, 29
12.	"Оюудент" ХХК	18

__оОо__